



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 27 өдөр

Дугаар А/398

Мандалговь

Аж ахуйн нэгж байгууллагын тооллого
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "з" дэх заалт, Засгийн газрын 315 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аж ахуйн нэгжийн 2021 оны ээлжит тооллогыг 2021 оны 11 дүгээр сарын 01-нээс 30-ны өдрүүдэд аймгийн хэмжээнд зохион байгуулж явуулах аймгийн тооллогын комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, сумын тооллогын комиссын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус байгуулсугай.

2. Аймгийн комиссоос өгсөн нэгдсэн удирдамж, заавар, чиглэлийн дагуу тооллогыг харьяа нутаг дэвсгэртээ чанартай зохион байгуулж, аж ахуйн нэгж байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгч бүрийг тооллогод бүрэн хамруулж, тоологч нарын халдвар хамгаалал, аюулгүй байдлыг хангаж ажиллах, аж ахуйн нэгжийн ээлжит тооллогын ажилд хяналт тавин, дүн мэдээг нэгтгэж, тооллогын үйл ажиллагааг явуулсан тайлан, илтгэх хуудсыг бэлтгэн аймгийн комисст 2021 оны 11 дүгээр сарын 30-ны дотор хүлээлгэн өгөхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Аж ахуйн нэгж байгууллагын тооллогын бэлтгэл, зохион байгуулалтын ажлыг аймгийн түвшинд бүрэн хангаж, тооллогыг тогтоосон хугацаанд заавар, журмын дагуу чанартай явуулж, дүнг мэдээлэхийг комиссын дарга (М.Анхбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210561

Аймгийн Засаг даргын 2021 оны
10 дугаар сарын 27-ны өдрийн 1347 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

ДУНДГОВЬ АЙМГИЙН АЖ АХУЙН НЭГЖИЙН 2021 ОНЫ ЭЭЛЖИТ
ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Аж ахуй нэгжийн 2021 оны ээлжит тооллогыг зохион байгуулах аймгийн тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: М.Анхбаяр (Аймгийн Засаг даргын орлогч)

Орлогч дарга: Б.Энхтуяа (Аймгийн Засаг даргын дэргэдэх
Статистикийн хэлтсийн дарга)

Гишүүд: Л.Доржбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Г.Энхтайван (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү,
төрийн сангийн хэлтсийн дарга)

М.Туяацэцэг (Татварын хэлтсийн дарга)

Ж.Өлзийжаргал (Улсын бүртгэлийн хэлтсийн дарга)

Н.Эрдэнэ-Очир (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Б.Мөнхжаргал (Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга)

Б.Алтантөгс (Эрүүл мэндийн газрын дарга)

Ц.Уранбямба (Боловсрол соёл урлагийн газрын даргын
үүргийн түр орлон гүйцэтгэгч)

Б. Мөнхбат (Цагдаагийн газрын дарга)

С.Бат-Оргил (Сайнцагаан сумын Засаг дарга)

Г.Хишигдаваа (Хөдөлмөр халамжийн үйлчилгээний
газрын дарга)

Б.Одонтунгалаг (Улсын бүртгэлийн хэлтсийн хуулийн
этгээдийн Улсын бүртгэгч)

Нарийн бичгийн дарга: Т.Бямбасүрэн (Аймгийн Засаг даргын дэргэдэх
Статистикийн хэлтсийн ахлах
мэргэжилтэн)

Аймгийн Засаг даргын 2021 оны
10 дугаар сарын 27-ны өдрийн 1/30 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

ДУНДГОВЬ АЙМГИЙН СУМДЫН АЖ АХУЙН НЭГЖИЙН ЭЭЛЖИТ
ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Аж ахуйн нэгжийн 2021 оны ээлжит тооллогыг зохион байгуулах сумдын
тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Сумын Засаг дарга

Гишүүд: Санхүүгийн хэлтсийн дарга

Татварын ажилтан

Улсын бүртгэгч

Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн

ЕБС-ийн захирал

Багийн Засаг дарга

Халамжийн мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Статистик хариуцсан мэргэжилтэн